



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 60

Сүхбаатар сум


**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Тариалангийн тухай хуулийн 21.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын 1.1 дэх заалтын 1.1.7-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. "Сэлэнгэ төмс, хүнсний ногоо хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг иргэд, ногоочид, тариаланчид, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоо орон нутгийн онцлогт тулгуурлан, нарийвчилсан төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Г.ВЯМБАА



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 18-ны  
өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



## “СЭЛЭНГЭ ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО” ХӨТӨЛБӨР

### Нэг. Төмс, хүнсний ногооны салбарын өнөөгийн байдал.

Монгол Улсын Их хурал, Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх тэр дундаа төмс, хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор “Атрын III аян”, “Хүнсний аюулгүй байдал”, “Ногоон хувьсгал” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Сэлэнгэ аймаг “Хүнсний ногоо” аймгийн хөтөлбөрийг 2012-2016 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлснээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй Улсын хэмжээний төмсний үйлдвэрлэлийн 35.2 хүртэл, хүнсний ногооны үйлдвэрлэлийн 25 хувийг үйлдвэрлэх хэмжээнд хүрсэн.

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл нь гар ажиллагаа ихтэй, нарийн технологитой, шинэ технологи нэвтрүүлэхэд өртөг өндөртэй байдаг. Өнөөдөр аймгийн хэмжээнд хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин 10 хувь, төмсний механикжуулалтын түвшин 40 хувьтай байгаа бөгөөд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийн 96.5 хувь нь талбайгаа энгийн аргаар боловсруулж байна. Түүнчлэн хүнсний ногооны нийт үйлдвэрлэлд хамгаалагдсан хөрсний аж ахуйн үйлдвэрлэл 0.2 хүрэхгүй хувийг эзэлж, 5.9 га хүлэмж (өвлийн 0.2 га, зуны 5.7 га)-ээс 250 тонн хүнсний ногоо хураан авч байна.

2012-2016 онд төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдэд 5.4 тн бөөрөнхий сонгины үр, 95 кг сонгины хар үр, 55 кг сармисны булцуу, 110 кг байцааны үр, 33 кг хүрэн манжин, 38 кг шар манжингийн үрийн болон бага оврын трактор 380 ш, хүнсний ногооны үрлэгч 18 ширхэг, сийрүүлэгч 8 ширхэг буюу нийт 401 тооны техникийг хөнгөлөлттэй үнээр олгож дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 3118 иргэн, 64 аж ахуйн нэгж 3144.5 га талбайд төмс, 2367.3 га талбайд хүнсний ногоо тариалж жилд дундажаар 31.8 мянган тн хүнсний ногоо, 45.9 мянган тн төмс хураан авч аймгийн нийт хүн амын хүнсний ногооны хэрэглээг бүрэн хангаж, 21.8 мянган тн хүнсний ногоо, 26.4 мянган тн төмсийг зах зээлд худалдан борлуулж байна.

Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэгч иргэдийн тоо 2017 онд 2012 оныхоос 47.4 хувиар, төмсний тариалалт 37.1 хувиар тус тус буурсан.

Аймгийн хэмжээнд үйлдвэрлэсэн төмсний 45 хувь, хүнсний ногооны 30 хүрэхгүй хувийг нь зориулалтын зоорь, агуулахад хадгалж, үлдэх хэсгийг маш хямдаар борлуулж байгаа нь төмс, ногоо эрхлэгчдийн орлогод сөргөөр нөлөөлж үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо буурах үндэслэл болж байна.

2017 онд Мандал суманд 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Нэвтрүүлэх төв”-ийн байрыг ашиглалтад оруулсан нь ногоочдын хамтарч ажиллах хөдөлмөр зохион байгуулалтыг шинэлэг хэлбэрээр бүрдүүлэх эхлэлийг бий болголоо.

Ногоочдын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан 40 гаруй бүлэг, хоршоодод 332 ногоочид хамрагдаж, борлуулалтын дундын хоршоог байгуулах ажлыг “Монгол ногоо” төслийн багтай хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

## **Хоёр. “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлж, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн хөгжлийн явц, үр дүнг сайжруулахаар аймгийн “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” хөтөлбөрийг боловсруулж байна.

Өрхийн үйлдвэрлэлээс гадна ногооны төрөлжсөн аж ахуй, хоршоодын хүнсний ногоо тариалах талбай, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, зоорины багтаамжийг нэмэгдүүлэн, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ногооны үрийн аж ахуйг бэхжүүлэх, усалгааны хэмнэлттэй техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, борлуулалтыг дэмжиж төмс, хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуйн нэгжийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

**3.1. Хөтөлбөрийн зорилго нь:** Орчин үеийн дэвшилтэт техник, технологийг төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд нэвтрүүлж, салбарын тогтвортой хөгжлийн ханган, хүнсний ногооны төрөл зүйлийг нэмэгдүүлж, “Сэлэнгэ нутгийн брэнд”-ийг бий болгон улсын хэмжээний үйлдвэрлэлд эзлэх байр суурийг нэмэгдүүлж, гадаад зах зээлд нийлүүлэх боломжийг хангахад чиглэгдэнэ.

**3.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлнэ.**

**3.2.1.** Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжилтэй боловсон хүчнийг мэргэжлийн байгууллагуудаар дамжуулан бэлтгэх, ногоочдыг чадавхижуулах, анхан шатны санхүүгийн сургалтыг орон нутагт нь зохион байгуулж, мэдээ, мэдээллээр хангаж хүний нөөцийн чадавхийг сайжруулах

**3.2.2.** Төмс, хүнсний ногооны нутагшсан сортын үр үржүүлэх арга ажиллагааг дэмжиж, үрийн хангамжийг нэмэгдүүлэн, “Сэлэнгэ” нэртэй төмс, хүнсний ногооны сортыг бий болгох

**3.2.3.** Үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, өрхийн хэмжээнд тохирсон төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг эрчимжүүлж, хүлэмжийн аж ахуй, зорь агуулахын багтаамж, бага, дунд оврын техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

**3.2.4.** Өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх таатай орчинг бий болгож, төмс, хүнсний ногоо боловсруулах жижиг дунд үйлдвэр болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, борлуулалтын сүлжээг бий болгох

### **Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**4.1. Хөтөлбөрийн 3.2.1.-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

**4.1.1.** Хөтөлбөрийг сурталчилах, төмс, хүнсний ногоо тариалагч иргэн аж ахуйн нэгжид зориулсан сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах

**4.1.2.** Төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийн туршлага солилцох гадаад дотоодын бизнес аялалыг зохион байгуулах

**4.1.3.** Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах

4.1.4. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн талбайн эзэмшлийн хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, шинэчлэн тогтоож, эзэмшил ашиглалтыг сайжруулан талбайн хэмжээг нэмэгдүүлэх

4.1.5. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран төмс, хүнсний ногооны мэргэжилтэй тариаланчдыг бэлтгэх

**4.2. Хөтөлбөрийн 3.2.2.-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

4.2.1. Төмс, хүнсний ногооны үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Сэлэнгэ брэнд”-ийн сортуудыг бий болгож нутагшсан үрийг төмс, хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцлөөр олгох

4.2.2. Стандартын шаардлага хангасан ургамал хамгааллын болон ургалтыг идэвхжүүлэгч бодис, биологийн гаралтай бордооны хангамжийг нэмэгдүүлэх

4.2.3. Хүнсний ногооны шинэ нэр төрөл бүхий хадгалалт даах чадвартай хүнсний таримлуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх

4.2.4. Ногооны үр үйлдвэрлэл эрхлэгчдэд үрсэлгээ бойжуулах зориулалтын хүлэмжийн аж ахуй байгуулахад нь дэмжлэг үзүүлэх

4.2.5. Хүнсний ногооны ургамлыг бүс нутгийн онцлогоор нь төрөлжүүлэн хөгжүүлэх

**4.3. Хөтөлбөрийн 3.2.3.-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

4.3.1. Хүлэмж, зоорины аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн санал, санаачлагыг дэмжин, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

4.3.2. Төмс, хүнсний ногооны бүлэг, хоршоодын тоог 2 дахин нэмэгдүүлж, загвар бүлэг хоршоог байгуулан, хөнгөлөлттэй зээл, тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах

4.3.3. Хүнсний ногоо тариалагч иргэдийг тариалалтын болон хураалтын бага, дунд оврын техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, лизингийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах

4.3.4. Хүнсний ногооны үйлдвэрлэгч залуу гэр бүл, залуучуудад гарааны бизнес эрхлэх техник, тоног төхөөрөмжийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

4.3.5 Ногоочдын бүлэг, хоршоо, иргэдийг ажиллагаа багатай, дуслын услалтын системээр ханган ногооны талбайг хашаажуулах замаар нэгж га талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх

**4.4. Хөтөлбөрийн 3.2.4.-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

4.4.1. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод борлуулалтын цэгтэй төмс, хүнсний ногоо хадгалах зоорь байгуулах асуудлыг холбогдох газруудтай хамтран шийдвэрлэх

4.4.2. Сургуулийн үдийн цай, цэцэрлэгийн болон төсвийн байгууллагын төмс, ногооны хэрэгцээг тухайн орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах

4.4.3. Хүнсний ногоог хатаах, боловсруулах тоног төхөөрөмжөөр хангах, үйлдвэрүүдийг бүсчлэн байгуулах

4.4.4. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг тухайн орон нутгийн иргэдээс шууд худалдан авах талаар сум орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах гэрээнд тусгах арга хэмжээ авах

4.4.5. “Сэлэнгэд үйлдвэрлэв”, “Сэлэнгийн ногоон өдрүүд” арга хэмжээг Улаанбаатар хот болон зарим аймгийн төвүүдэд зохион байгуулах

**Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, арга зам, хамтын ажиллагаа**  
“Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” хөтөлбөрийг 2018-2024 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 5.1 Нэгдүгээр үе шат 2019-2021 он
- 5.2 Хоёрдугаар үе шат 2021-2024 он

**Нэгдүгээр үе шат: 2019-2021 онуудад хэрэгжүүлэх:**

5.1.1. Хөтөлбөрийг сурталчилах, төмс, хүнсний ногоо тариалагч иргэн аж ахуйн нэгжүүдэд өвлийн саруудад ногоочдыг шат дараалсан мэргэжлийн сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах

5.1.2. “Насан туршийн боловсрол төв”, МСҮТ-өөр дамжуулан залуу ногоочдыг бэлтгэн сургах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

5.1.3. Японы Шизуоки мужтай хүнсний ногооны чиглэлээр хамтран ажиллаж жил бүр 5 доошгүй ногоочдыг дадлагажуулах сургалтанд хамруулах

5.1.3. Сумдуудад шинэ техник, технологи нэвтрүүлэх сургалтын төвийг барьж байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах ажлыг зохион байгуулах

5.1.4. Дундын хоршооны үйл ажиллагааг идэвхижүүлэх

5.1.5. Жилд 1-2 аймагт төмс, хүнсний ногоо худалдан борлуулах зорилгоор “Сэлэнгийн ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулан борлуулалтыг нэмэгдүүлэх

5.1.6. 2019 оноос эхлэн “Сэлэнгэ брэнд” төмс, хүнсний ногооны төрлийг баталгаажуулах

**Хоёрдугаар үе шат: 2022-2024 онуудад хэрэгжүүлэх:**

5.2.1. Эдийн засаг, санхүү, төлөвлөлт, орлого зарлага тооцох анхан шатны сургалтуудыг зохион байгуулах

5.2.2. Төмс, хүнсний ногоог хатаах арга зүйд сургах,

5.2.3. Ногоо боловсруулах бага оврын үйлдвэр цехийг ногоочдын холбоо, бүлэгт хөнгөлөлттэй нөхцөөр олгох арга хэмжээг зохион байгуулах

**5.3. Хамтийн ажиллагаа.**

5.3.1. “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд Монгол дахь Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Монгол ногоо” төсөл, “Тогтвортой амьжиргаа-3” төсөл, Монгол-Германы техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн газар, төрийн бус байгууллагууд, хөдөө аж ахуй, бизнес эрхлэгчидтэй хамтран хэрэгжүүлж ажиллана.

**Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

6.1. Аймгийн хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулж, сумдад Засаг даргын орлогч, хөдөө аж ахуйн тасгийн агрономи, газрын даамал, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид, хоршооны холбоо, чөлөөнд гарсан туршлагатай ахмад мэргэжилтнүүдийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүр төлөвлөж тухайн ажлын хэсгийн ахлагчаар батлуулан шат шатны Засаг даргын зөвлөлд танилцуулан хэрэгжүүлнэ.

**Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт**

7.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

7.2. Сум хөгжүүлэх сан

7.3. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан

7.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

7.5. Олон Улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, хөрөнгө оруулалт

7.6. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр

**Найм. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахи шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Суурь түвшин /2017 он/	Зорилтот түвшин	
					1-р үе шат	2-р үе шат
1.	Улсын хэрэгцээт	Хүнсний ногооны	хувь	39.7	41	45
		Төмсний	хувь	26.7	30	35
2.	Гол нэрийн хүнсний ногооны тариалалт		га	2311	2400	2500
3.	Нарийн ногооны тариалалт		га	42	50	60
4.	Талбайн хэмжээ	Хүнсний ногоо	га	2367.3	2550	2700
		Төмс	га	3144	3450	3600
5.	Ургац	Хүнсний ногоо	мян.тн	31.9	34.4	36.1
		Төмс	мян.тн	31.1	33.8	35.3
6.	Борлуулалт	Хүнсний ногоо	мян.тн	21.8	25.6	32.5
		Төмс	мян.тн	26.5	36.8	42.6
7.	Хүлэмжийн төрөл	Өвлийн	га	0,2	0.5	1
		Зуны	га	5,7	7	10
8.	Зоорины багтаамж		тн	36,7	50,0	60.0
9.	Усалгаатай талбайн хэмжээ		га	4500	4700	5000
10.	Техник тоног төхөөрөмжийн хангамж	Хүнсний ногоо	хувь	10	15	21
		төмс	хувь	40	46	52
11.	Төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийн тоо		тоо	3182	4000	5000
12.	Урт болон дунд хугацааны сургалтанд хамрагдсан иргэдийн тоо		тоо	170	Жилд дунджаар 200 доошгүй төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийг сургалтанд хамруулах	
13.	Төмс, хүнсний ногоо боловсруулах жижиг, дунд үйлдвэрийн тоо		тоо	2	3	5
14.	Төмс, хүнсний ногоо тариалагч бүлэг, хоршоо		тоо	40	60	80

### Ногоочдын судалгаа

№	Сумдын нэр	Төмс, хүнсний ногоо тариалагч иргэд	Насны ангилал			Нийт талбайн хэмжээ /га/		Талбайн хэмжээ /иргэн/								Зорины багтаамж /тн/			Хүлэмж /мян.м2/			техникийн хангамж		Ногоочдын бүлэг
			18-29	30-39	40-өөс дээш	төмс	Хүнсний ногоо	0.01-0.1	0.1-0.5	0.5-1	1-2	2-5	5-10	10-аас дээш	энгийн	механик	Зуны /мян.м2/	өвлийн	га	бага оворын	дундавын	Ногоочдын бүлэг		
1	Алтанбулаг	185	29	95	61	98.6	57.5	42	96	25	20	2	185		1.1		0.11				1	20		
2	Ерөө	211	25	98	74	86.7	69.7	91	57	30	17	4	265				0							
3	Мандал	1289	187	399	703	597.4	425.4	696	432	73	30	16	9335	1750	34.1	1920	3.41	7	3	19				
4	Зүүнбүрэн	177	16	50	111	106.8	284.4	3	34	48	45	8	337		2.9		0.29			4	36			
5	Орхон	154	18	47	89	340.8	121.1	1	9	3	24	11	93		3.6		0.36	11	10	1	64			
6	Сант	129	9	24	96	216	174.3		23	18	34	7	1330		1.6		0.16			2	22			
7	Түшиг	24		5	19	60.6	25	2	21	1			170				0			1	1	3		
8	Баянгол	184	1	22	161	132.1	84.8	19	94	31	20	4	3090		1	0.048	0	8	2	66				
9	Сайхан	102	12	47	43	256	203.5		8	43	19	13	619				0							
10	Жавхланта	47		16	31	60.6	83.9		10	5	14	3	712		0.3		0.04	20	2	1	20			
11	Орхонтул	27	4	11	12	34.6	63.3	2	2	1	5	2	327				0							
12	Баруунбүрэн	67	2	10	55	95	77		14	18	16	4	118				0							
13	Цагааннуур	11		11	11	523.7	199.3	1			2	4	29	16000			0							
14	Хушаат	95	16	43	36	275.6	161.3		12	30	22	4	258				0							
15	Шаамар	276	49	51	176	100.9	246.8	24	104	57	45	8	495		4.2		0.42			3	30			
16	Хүдэр	46	12	15	19	81	38.1			21	17		65		0.4		0.04			1	23			
17	Сүхбаатар	158	37	56	65	78.1	51.9	7	70	39	23	6	1574.2		9.1		0.91			5	48			
	Нийт дүн	3182	417	989	1762	3144.5	2367.3	888	986	443	353	333	19002.2	17750	57.3	1920.1	5.73	46	35	40	332			

Төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч иргэдийг насжилтаар нь авч үзвэл 18-29 насны 417 иргэн, 30-39 насны 989 иргэн, 40-өөс дээш насны 1762 иргэн байна.

Мөн нийт төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийн талбайн ангилалаар нь авч үзвэл 0,01-0,1 га талбайтай 888 иргэн буюу 27.9 хувь, 0,1-0,5 га талбайтай 986 иргэн буюу 31 хувь, 0,5-1 га талбайтай 443 иргэн буюу 13.9 хувь, 1-2 га талбайтай 353 иргэн буюу 11.1 хувь, 2-5 га талбайтай 333 иргэн буюу 10.5 хувь, 5-10 га талбайтай 112 иргэн 3.5 хувь, 10 дээш га талбайтай 67 иргэн буюу 2.1 хувийг эзлэж байна.

Дээрх судалгаанаас үзэхэд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийн дийлэнх хувь нь буюу 58,9 хувийг 0,01-0,5 га талбайтай 1874 иргэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 18-ны  
едрийн 60 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“Сэлэнгэ төмс, хүнсний ногоо хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх  
арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төсөвт өртөг /мянган төгрөг/	Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх байгууллага
1	Хөтөлбөрийг сурталчилах ажлыг сумдад зохион байгуулах, төмс, хүнсний ногоо тариалагч иргэн аж ахуйн нэгжүүдэд өвлийн саруудад ногоочдыг шат дараалсан мэргэжлийн сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах	Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Ногоочдын орлого зарлагаа тооцох мэдлэгтэй болсон байна	Сумдын засаг даргын Тамгын газар, ногоочдын бүлэг, хоршоодын удирдлага
2	“Насан туршийн боловсрол төв”, МСҮТ-өөр дамжуулан залуу ногоочдыг бэлтгэн сургах	Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Залуу боловсон хүчний нөөц бий болсон байна.	Сумдын ЗДТГ
3	Японы Шизуоки мужтай хүнсний ногооны чиглэлээр хамтран ажиллаж жил бүр 5 доошгүй мэргэжилтэй ногоочдыг дадлагажуулах сургалтанд хамруулах.	Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Нарийн мэргэжлийн ногоочдын тоо нэмэгдсэн байна	Аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ
4	Сумдуудад шинэ техник, технологи нэвтрүүлэх сургалтын төвийг барьж байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах ажлыг зохион байгуулна	Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Ногоочдын бүлэг, хоршоодын тоо нэмэгдэж, мэдээлэл, технологийн дэвшлийг нэвтрүүлэх боломжоор хангагдана.	Сумдын Засаг даргын Тамгын газар
5	Дундын хоршооны үйл ажиллагааг идэвхижүүлнэ.	Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Төмс, ногооны борлуулалтын үйл ажиллагаа сайжирна,	Сумдын Засаг даргын Тамгын газар



		Жил бүр	Зардлын гүйцэтгэлээр	Тогтворжино.	Аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ
6	Жилд 1-2 аймагт "Сэлэнгийн ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж борлуулалтыг нэмэгдүүлнэ.	Жил бүр	500,0	2018 онд Дундговь аймагт	Аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ
7.	2019 оноос эхлэн Орхоны сумын Шийрийн эрт ургацын төмс, Мандал, Алтанбулаг сумдын эртийн болон оройн байцаа, эртийн голгүй лууван, Шаамар сумын сонгино, шийгуаг "Сэлэнгийн брэнд"-ээр баталгаажуулах	Жил бүр		Шинээр Сэлэнгийн бренд нэмэгдсэн байна.	ХХААГазар, сумдын ЗДТГ, ногоочдын холбоо
8.	Хөв цөөрөм барих замаар гүний усны хэрэглээг багасгах, ус бага зарцуулдаг дуслын усалгааны системийг нэвтрүүлэх	Жил бүр	200,0 сая төгрөг		
<b>Хоёрдугаар үе шат 2022-2024 он.</b>					
1.	Эдийн засаг, санхүү, төлөвлөлт, орлого зарлага тооцох анхан шатны сургалтуудыг зохион байгуулна.	Жил бүр	1500,0	Тариаланч, ногоочдын эдийн засгийн мэдлэг дээшилсэн байна	ХХААГазар, сумдын ЗДТГ
2.	Төмс, хүнсний ногоог хатаах арга зүйд сургах, техник тоноглолоор хангах	Жил бүр	8000,0	Ногоог Боловсруулах, савлах мэдлэг дээшилсэн байна. Борлуулалтын орлого нэмэгдэнэ.	ХХААГазар, сумдын ЗДТГ иргэд
3.	Ногоо боловсруулах бага оврын үйлдвэр цехийг иргэн аж ахуйн нэгжийн оролцоотойгоор хамтран үе шаттайгаар байгуулна.	Жил бүр	Ком хатаах төхөөрөмжийн үнэ 3200,0 төгрөг, боловсруулах тоноглолын үнэ 15000,0 мянган төгрөг	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулах нөхцөл бүрэлдэж ногоочдын орлого нэмэгдэх нөхцөл бүрэлдэнэ.	ХХААГазар, сумдын ЗДТГ, иргэд

Аймгийн Засаг даргын Тамгын газар